



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын хөгжлийн
төвийн дүрэм, бүтэц, орон тооны
хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 56 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн дүрмийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар, орон тооны дээд хязгаарыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Х.Бакытжан/-д даалгасугай.

3. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийг байгуулсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2012 оны А/54 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

080223

Эрүүл мэнд, спортын сайдын 2015
оны 09 дугаар сарын 18-ны өдрийн 6.7
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Биеийн тамир, спортын хөгжлийн төв” /цаашид төв гэх/ нь Биеийн тамир, спортын салбарын бодлого, хөтөлбөр, хууль, дүрэм, журам, стандартыг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, шийдвэр гаргагчдыг нотолгоо, статистик тоо, мэдээллээр хангах, хүн амд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээ хүргэдэг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон үндэсний шигшээ баг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг анагаах ухаан, судалгаа шинжилгээний үндсэн дээр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, салбарын хүний нөөцийн хөгжил, тэмцээн, наадмын тогтолцоо, биеийн тамир, спортын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх бодлогын хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.2. Төвийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.3. Төв нь үйл ажиллагаандаа Биеийн тамир, спортын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4. Төв нь байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөгөө, түүнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна. Байгууллагын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө нь салбарын бодлого, яамнаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдсан байна.

1.5. Төв нь зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Төв нь өөрийн бэлгэдэлтэй байж болно.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зорилго, зарчим

2.1 Төвийн эрхэм зорилго:

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын цогц хөтөлбөрийн хүрээнд нийтийн биеийн тамир, спорт, үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг судалгаа шинжилгээний үндсэн дээр хүн амд болон өндөр зэрэглэлтэй тамирчдад хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах ажлыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд оршино.

2.2 Төвийн үйл ажиллагааны зарчим

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцыг чанд сахих;
- Ил тод, нээлттэй ажиллах,
- Төрийн албан хаагчийн ёс зүй, хуулийг мөрдлөг болгох.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дор дурдсан үүрэгтэй байна. Үүнд:

3.1.1. Монгол Улсын хууль, тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах;


- 3.1.2. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэл, үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, зарлиг, тогтоол шийдвэр, хөтөлбөр, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг улирал, жилээр болон тогтоосон хугацаанд тайлагнах.
 - 3.1.3. Төвийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөлтийг боловсруулж Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, холбогдох эрх бүхий албан тушаалтнаар батлуулан ажиллах, биелэлтийг хангах;
 - 3.1.4. Батлагдсан төсвийн хүрээнд нийтийн биеийн тамир, спорт, эрдэм шинжилгээ, судалгаа, үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний дотоод, гадаадын бэлтгэл сургалт, тэмцээний зардал, цалинд зориулан батлагдсан санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах;
 - 3.1.5. Үндэсний шигшээ баг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг спортын анагаах ухаан, судалгаа шинжилгээний үндсэн дээр хангах,
 - 3.1.6. Салбарын байгууллага болон иргэдэд нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжилтийн чиглэлээр хичээллэх, арга хэмжээ зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөмж чиглэл өгөх,
 - 3.1.7. Иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, чийрэгжилтийн арга хэмжээ зохион байгуулах, бие бялдрын түвшин тогтоох сорил авах, дүн мэдээг улсын хэмжээнд нэгтгэж танилцуулах,
 - 3.1.8. Хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээ, үндэсний хэмжээний тэмцээн, наадмыг төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.9. Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны ажлын албаны үүрэг хүлээх;
 - 3.1.10. Төрийн өмчийн хороотой байгуулсан гэрээний дагуу Спортын төв ордны ажил, үйлчилгээний орлогын зарим хэсгийг улсын төсөвт төвлөрүүлэх;
 - 3.1.11. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл тооцоог Олон улсын нягтлан бодох стандартын дагуу мөрдөх, хуулийн хугацаанд тайлан мэдээг гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх;
 - 3.1.12. Төвийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйлчлэн зохицуулах чиг үүрэг бүхий нэгж, албатай байна.
 - 3.1.13. Тамирчдын бэлтгэлжилтийн түвшинг тодорхойлох, эрүүл мэндийг хянах, өвчин, бэртэл, гэмтэлд эмнэлэгийн тусламж үйлчилгээг үзүүлэх;
 - 3.1.14. Үндэсний шигшээ баг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг хангуулах ба хяналт тавих;
 - 3.1.15. Биеийн тамир, спортын чиглэлээр төрөл бүрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;
 - 3.1.16. Спортын төв ордны хэвийн үйл ажиллагааг хангах;
- 3.2. Төв нь дор дурдсан эрхтэй байна.**
- 3.2.1. Өөрт олгогдсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;
 - 3.2.2. Ажлын уялдаа холбоо, дотоод үйл ажиллагааг хангах асуудлаар заавар, журам, даалгавар, удирдамж гаргах;
 - 3.2.3. Бүх шатны биеийн тамир, спортын байгууллагуудаас биеийн тамир, спортын мэдээ, мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийх;

- 3.2.4. Монгол Улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагуудтай эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, гэрээ байгуулах;
- 3.2.5. Тухайн жилд батлагдсан цалингийн сандаа багтаан боловсон хүчнийг сонгон шалгаруулах зарчмаар ажилд авах, хуулийн хүрээнд ажилд томилох, чөлөөлөх;
- 3.2.6. Төв нь өөрийн байгууллагын шагнал, өргөмжлөл, тэмдэгтэй байна. Шагнал, урамшуулал олгох журмыг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн захирлын шийдвэрээр баталгаажуулна;
- 3.2.7. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд, үйлчлүүлэгчдэд биеийн тамир, спортын мэдээ мэдээллийг түгээх зорилгоор цахим хуудас, мэдээний сан зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээтэй байх;
- 3.2.8. Эрхлэх асуудлын хүрээнд ном, гарын авлага, эмхэтгэл зэргийг гаргах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөх;

Дөрөв. Төвийн удирдлага

- 4.1 Төвийн удирдлагын бүтэц нь Захирал болон Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.
- 4.2 Төвийн Захирал нь төвийн үндсэн чиг үүрэг, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө болон Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, энэхүү дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 4.3 Удирдлагын зөвлөл нь Захирлыг шийдвэр гаргах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.4 Төвийн зохион байгуулалтын нэгж нь хэлтэс, алба байх бөгөөд нэгжийг хэлтэс, албаны дарга удирдана.
- 4.5 Төвийн Удирдлагын зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг төвийн захирал батална. Удирдлагын зөвлөлийг захирал удирдана.
- 4.6 Төв нь I) Захиргаа, санхүүгийн хэлтэс, II) Нийтийн биеийн тамир, спортын хөгжлийн хэлтэс, III) Биеийн тамир, спортын эрдэм шинжилгээ, сургалтын хэлтэс, IV) Үндэсний шигшээ багийн алба, V) Спортын анагаах ухааны албатай байна.
- 4.7 Төвийн Захирал тушаал, Удирдлагын зөвлөл хурлын тэмдэглэл гаргана.
- 4.8 Төвийн захирлыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.
- 4.9 **Захирлын эрх үүрэг:**
- 4.9.1 Захирлын эрх:**
- 4.9.1.1 Төвийн хэлтэс, албадын үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, хөгжлийн хөтөлбөр, ойрын болон хэтийн хөгжлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 4.9.1.2 Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан албадын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;
- 4.9.1.3 Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;
- 4.9.1.4 Төвийн албан хаагчдыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

- 4.9.1.5 Ажилтныг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах, захиргааны чөлөө олгох;
- 4.9.1.6 Ажлын үр дүнг үндэслэн ажилтнуудыг шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх;
- 4.9.1.7 Хуулиар олгогдсон бусад эрх.



4.9.2 Захирлын үүрэг:

- 4.9.2.1 Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;
- 4.9.2.2 Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид ажиллах;
- 4.9.2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр хөдөлмөрийн гэрээ, үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;
- 4.9.2.4 Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлангийн үнэн зөв байдлыг хариуцах;
- 4.9.2.5 Ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- 4.9.2.6 Ажилтны талаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
- 4.9.2.7 Хуульд заасан бусад үүрэг.

4.10 Захирал нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- 4.10.1 Дээд боловсролтой, төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан, удирдах албан тушаал эрхэлж байсан туршлагатай, гадаад хэлний зохих мэдлэгтэй байх;
- 4.10.2 Удирдлагын ёс зүйн хэмжээг зөв ойлгож, хэрэгжүүлж чаддаг, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хасаагүй, эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээгүй байх;
- 4.10.3 Захирал нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох чиглэлээр ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой.
- 4.10.4 Захирал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол түүнийг ажлаас халах үндэслэл болно.
- 4.11 Төв нь ажилтнуудын нийгэм хамгаалал, эрх ашгийг хамгаалах, тэдний сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Хамт олны зөвлөл”-тэй байж болно.
- 4.12 Хамтын олны зөвлөлийн бүрэлдэхүүнийг төвийн нийт ажилтны хурлаар хэлэлцэж сонгох бөгөөд хамт олны зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн сонгоно.

Тав. Төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа

- 5.1 Төв нь Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд яам, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.
- 5.2 Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад биеийн тамир, спортын байгууллага, иргэдтэй шууд харилцана.

5.3 Хууль, журмын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, хувь хүнтэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ, хэлцэл байгуулан баталгаажуулан ажиллана.

5.4 Гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, зочид, төлөөлөгч урих, үндсэн чиг үүргийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр гадаад харилцаагаа хөгжүүлэн ажиллана.

5.5 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээнд байгууллагаа төлөөлж гарын үсэг зурах эрхийг Захирал эдлэнэ.

5.6 Төвийн захирлын гадаад, дотоод томилолтыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, төвийн бусад ажилтнуудын гадаад, дотоод томилолтын асуудлыг төвийн захирлын шийдвэрээр баталгаажуулна.

Зургаа. Төвийн хэлтэс, албадын үндсэн чиг үүрэг

6.1 Биеийн тамир, спортын эрдэм шинжилгээ, сургалтын хэлтсийн үндсэн чиг үүрэг:

6.1.1 Нийтийн биеийн тамир, спортын болон үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг судалгаа, шинжилгээний үндэслэлтэй явуулахад дэмжлэг үзүүлэх;

6.1.2 Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлын цар хүрээ, тоо, чанар, нэр төрлийг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоож, их, дээд сургууль, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран болон гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх,

6.1.3 Салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж, төгсөлтийн дараах сургалтын шатлал, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах ажлыг их, дээд сургууль, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

6.1.4 Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах, оролцох, спортын шинжлэх ухааны шинэ нээлт, ололт, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг нэвтрүүлэх;

6.1.5 Зорилтот бүлгүүдэд зориулсан сургалтын ном, гарын авлага, зөвлөмж, сургалт дасгалжуулалт, төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, нийтийн хүртээл болгох;

6.2 **Нийтийн биеийн тамир, спортын хөгжлийн хэлтсийн үндсэн чиг үүрэг:**

6.2.1 Салбарын статистик, тоо мэдээг холбогдох байгууллагаас гаргуулж үндэсний хэмжээнд нэгтгэн Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

6.2.2 Аймгийн болон нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудад хүн амыг биеийн тамир, спорт, идэвхтэй хөдөлгөөнөөр зөв хичээллэх мэдлэг, дадал, чадвар төлөвшүүлэх мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах;

6.2.3 Иргэдийн дунд нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжилтийн арга хэмжээ зохион байгуулж, биеийн тамир, спортод татан оролцуулах, тэдгээрийг биеийн тамир, спортоор зөв хичээллэх мэдлэг, мэдээлэл, сурталчилгааны ажлыг явуулах;

- 6.2.4 Монгол улсын спортын амжилтыг хадгалах, ахиулах, өндөр зэрэглэлийн тамирчдын залгамж халааг бэлтгэх чиглэлээр үндэсний хэмжээнд явагдах спортын тэмцээн, наадмын зохион байгуулалтыг хангах;
- 6.2.5 Спортын цол, Засгийн газрын мөнгөн шагнал олгох ажлыг холбогдох журмын дагуу бүрдүүлэн Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар шийдвэрлүүлэх;
- 6.2.6 Биеийн тамир, спортын байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, дүгнэлтийг Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;
- 6.2.7 Зорилтод бүлгүүдэд зориулсан сургалтын ном, гарын авлага, зөвлөмжийг боловсруулах, нийтийн хүртээл болгох, түгээх;
- 6.2.8 Биеийн тамир, спортын үйл ажиллагаа, спортын сургалт, дасгалжуулалт, үйлчилгээ явуулах орчин нөхцлийг бүрдүүлэх стандарт, норм, нормативийг боловсруулах;
- 6.2.9 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, дүн мэдээг нэгтгэх, тайлагнах.
- 6.3 Захиргаа, санхүүгийн хэлтсийн үндсэн чиг үүрэг:**
- 6.3.1 Санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, техник технологийг сайжруулах, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, шинэ дэвшилтэт санхүүгийн программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- 6.3.2 “Буянт-Ухаа биеийн тамир, спортын ордон”, “Техник, спортын төв”, Булган аймгийн Хангал суман дахь “Спортын сургалт, бэлтгэлийн төв” болон бусад спортын байгууламжыг түшиглэн нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжилтийн арга хэмжээ, Үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилыг төлөвлөгөөтэй явуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 6.3.3 Төвийн ажилтан, албан хаагч, үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдын ерөнхий мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэдний хүмүүжил ёс зүйд хяналт тавих, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;
- 6.3.4 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;
- 6.4 Үндэсний шигшээ багийн албаны үндсэн чиг үүрэг:**
- 6.4.1 Тамирчдын тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн болон олимпын наадамд үзүүлсэн амжилтыг хадгалах, ахиулах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, спортын анагаах ухааны судалгаа, дүгнэлтэнд тулгуурлан, спортын холбоодтой хамтран хэрэгжүүлэх;
- 6.4.2 Үндэсний шигшээ багуудын тэмцээн, уралдааны жилийн календарчилсан төлөвлөгөөг спортын холбоодтой хамтран боловсруулах, хэлэлцүүлэн батлуулах;
- 6.4.3 Үндэсний шигшээ багийн тамирчдын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, холбогдох гэрээ, контракт байгуулах ажлыг хэрэгжүүлэх;
- 6.4.4 Үндэсний шигшээ багуудын сургалт дасгалжуулалтын урт, богино хугацааны төлөвлөгөөг хянаж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 6.4.5 Үндэсний шигшээ багийг гэрээний дагуу ажиллуулах, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг хангах нөхцөл бололцоог бүрдүүлэх;

- 6.4.6 Тамирчдын бэлтгэл сургуулилтаа тасралтгүй, чанартай хийх нөхцөл бололцоог бүрдүүлэх, хяналт тавих.
- 6.4.7 Олимп, тивийн наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд Үндэсний шигшээ багийн тамирчдыг бүрдүүлж, илгээх;
- 6.5 **Спортын анагаах ухааны албаны үндсэн чиг үүрэг:**
- 6.5.1 Үндэсний шигшээ багийн нийт бүрэлдэхүүнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай эм, витаминжуулалтаар хангах, үзлэг шинжилгээнд төлөвлөгөөний дагуу хамруулах;
- 6.5.2 Үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэлжилтийн түвшин, ажиллах чадварыг тогтоох, сорилт, шинжилгээг хийж дүгнэлт гаргах, дасгалжуулагч, тамирчдад зөвлөгөө өгөх;
- 6.5.3 Салбарын спортын эмч, дасгалжуулагч нарт спортын анагаах ухааны мэргэжил, арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгөх,
- 6.5.4 Тамирчдад үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, дасгалжилтын түвшин тогтоох, сорилт, шинжилгээ хийх, шинэ техник, технологи нэвтрүүлэх;
- 6.5.5 Үндэсний шигшээ багийн өдөр тутмын бэлтгэл сургуулилт, өндөр ачаалалтай болон сэргэлтийн бэлтгэл, цугларалтын үе дэх сорилт, шинжилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих;

Долоо. Эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага

- 7.1 Төвийн захирал, ерөнхий нягтлан бодогч зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 7.2 Эрх бүхий албан тушаалтан нь Төвийн дүрэм, хөдөлмөрийн гэрээ, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, холбогдох хуулийг баримтлан төвийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.
- 7.3 Эрх бүхий албан тушаалтан болон Төвийн ажилтан, албан хаагч нь дараахь хууль бус үйл ажиллагааг явуулсан бол ажлаас чөлөөлөгдөх үндэслэл болно. Үүнд:
- 7.3.1 Хувийн ашиг сонирхлын үүднээс байгууллагын нэрийг ашиглан үйл ажиллагаа явуулсан;
- 7.3.2 Төрийн өмчийн эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хувийн болон гуравдагч этгээдэд эзэмшүүлж, ашиглуулсан;
- 7.3.3 Дүрэм болон төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, журам зөрчсөн;
- 7.3.4 Захиралтай байгуулсан гэрээ, байгууллагын дотоод журам, дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн;
- 7.3.5 Бусад
- 7.4 Эрх бүхий албан тушаалтан нь санаатайгаар хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас төвд хохирол учруулсан бол хохирлыг хуульд заасны дагуу хариуцна.

Найм. Санхүүгийн тайлан тэнцэл, бүртгэл

- 8.1 Төвийн тухайн жилийн орлого нь дараахь санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 8.1.1 Улсын төсвийн санхүүжилт;
- 8.1.2 Ажил, үйлчилгээнээс орсон орлого;
- 8.1.3 Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

8.2 Төв нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллана.

Ес. Хяналт шалгалт

9.1 Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтанд тавих хяналт шалгалт нь Үндэсний аудитын газар, Төрийн өмчийн хороо, Мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтаас бүрдэнэ.

9.2 Төвийн захирал нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг удирдах дээд байгууллагын өмнө хариуцна.

9.3 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.

Арав. Төвийн бичиг, баримтыг хадгалах

10.1 Төв нь Монгол улсын Архивын тухай хууль, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврийн дагуу бичиг баримтыг хадгална.

Арван нэг. Төвийн шагнал, урамшуулал

11.1 Төв нь урамшууллын дараах хэлбэрүүдийг хэрэглэж болно.

11.1.1 Төрийн одон, медалиар шагнагдсан салбарын зүтгэлтэнүүдийг “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулах,

11.1.2 Төвийн захирлын нэрэмжит шагнал “Спортын алдар” тэмдэг,

11.1.3 Биеийн тамир, спортын салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан бусад салбарын албан хаагчийг шагнах “Хүндэт тэмдэг” шагнал

11.2 Шагнал, урамшуулал олгох журмыг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн батална.

11.3 Төрийн ба төрийн бус байгууллагын шагналд болзол шалгуурыг хангасан албан хаагч нарыг тодорхойлон, шагнуулж урамшуулах нь төвийн эрх, үүрэг болно.

Арван хоёр. Төвийн үйл ажиллагаанд хориглох зүйл

12.1 Төв нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

12.1.1 Улс төр, шашны зорилготой үйл ажиллагаа зохион байгуулах

12.1.2 Хууль тогтоомжинд зааснаас бусад хэлбэрээр орлого олох үйл ажиллагаа явуулах

Арван гурав. Бусад

13.1 Энэхүү дүрэм нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын
2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 67
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬЯА БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН СХЕМ**

**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ**

Захиргаа, санхүүгийн хэлтэс	Биеийн тамир, спортын эрдэм шинжилгээ, сургалтын хэлтэс	Нийтийн биеийн тамир, спортын хөгжлийн хэлтэс	Үндэсний шигшээ багийн алба	Спортын анагаах ухааны алба
<ul style="list-style-type: none"> - Хэлтсийн дарга - Ерөнхий нягтлан бодогч - Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн - Гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн - Дотоод ажил, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн - Хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн - Тооцооны нягтлан бодогч - Төсвийн нягтлан бодогч - Нярав - Архив, бичиг хэргийн эрхлэгч - Зохион байгуулагч, менежер - Ерөнхий инженер - Үйлчлэгч - Слесарь, слесарь-гагнуурчин - Жолооч - Техникч - Цахилгаанчин - Мужаан - Манаач, жижүүр 	<ul style="list-style-type: none"> - Хэлтсийн дарга - Спортын сургалт-дасгалжуулалтын асуудал хариуцсан ахлах эрдэмтэн судлаач - Спортын анагаах ухаан хариуцсан эрдэмтэн судлаач - Спортын сэтгэл судлал хариуцсан эрдэмтэн судлаач - Спортын эрүүл мэнд, хооллолт судлалын судалгааны ажилтан - Биеийн ерөнхий хөгжил, биомеханикийн судлалын судалгааны ажилтан - Спортын менежмент, маркетинг судлалын судалгааны ажилтан 	<ul style="list-style-type: none"> - Хэлтсийн дарга - Сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн - Спортын тэмцээн, наадам хариуцсан мэргэжилтэн - Бие бялдрын боловсрол, магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн - Бие бялдрын сорил, стандарт хариуцсан мэргэжилтэн - Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн - Статистик, шагнал, урамшуулал, спортын цол, зэрэг хариуцсан мэргэжилтэн - Нийтийн биеийн тамирын арга хэмжээ, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> - Албаны дарга - Сургалт, дасгалжуулалтын төлөвлөлт хариуцсан, ахлах мэргэжилтэн - Сургалт, дасгалжуулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн - Зуны төрлүүд хариуцсан мэргэжилтэн - Зуны төрлүүд хариуцсан мэргэжилтэн - Пара болон өвлийн спортын төрлүүд хариуцсан мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> - Албаны дарга, - Ерөнхий эмч - Их эмч - Бага эмч - Сувилагч - Массажист

Эрүүл мэнд, спортын сайдын 2015
оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 67
тоот тушаалын гуравдугаар хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Албан тушаал	Орон тоо
1.	Захирал	1
2.	Хэлтсийн дарга	3
3.	Албаны дарга	1
4.	Албаны дарга, Ерөнхий эмч	1
5.	Ахлах мэргэжилтан	3
6.	Ахлах эрдэмтэн судлаач	1
7.	Мэргэжилтэн	13
8.	Эрдэмтэн судлаач	2
9.	Судалгааны ажилтан	3
10.	Их эмч	5
11.	Бага эмч	1
12.	Сувилагч	1
13.	Массажист	4
14.	Ерөнхий нягтлан бодогч	1
15.	Нягтлан бодогч	2
16.	Нярав	1
17.	Архив - бичиг хэргийн эрхлэгч	1
18.	Зохион байгуулагч менежер	1
19.	Ерөнхий инженер	1
20.	Үйлчлэгч	14
21.	Жолооч	1
22.	Техникч	1
23.	Цахилгаанчин	1
24.	Мужаан	1
25.	Слесарь, слесарь – гагнуурчин	4
26.	Манаач, жижүүр	3
Бүгд		71